

Төсөл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны ...
дугаар сарын ...-ны өдрийн дугаар
хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ШОШГОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.Монгол Улсад үйлдвэрлэсэн согтууруулах ундааны шошго нь дараах мэдээллийг агуулсан байна:

- 1.1.Согтууруулах ундааны нэр төрөл, цувралын дугаар;
- 1.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэгчийн нэр, хаяг;
- 1.3.Савлагааны хэмжээ;
- 1.4.Орц бүрдүүлэгч, хүнсний нэмэлтийн дугаар, тэмдэглэгээ;
- 1.5.Үйлдвэрлэсэн он, сар, өдөр, хадгалах нөхцөл;
- 1.6.Согтууруулах ундааны хатуулаг;
- 1.7.Стандарт, техникийн зохицуулалтын тэмдэглэгээ;
- 1.8.Согтууруулах ундаанаас үүдэлтэй эрүүл мэндийн хор нөлөөний анхааруулга;
- 1.9. Хадгалах хугацаа;
- 1.10.Гаж нөлөө, хориглох заалт;
- 1.11.Спиртийн ангилал;
- 1.12.Зураасан код;
- 1.13.Шимт бодисын мэдээлэл;
- 1.14.Хэрэглэх заавар.

2.Монгол Улсад үйлдвэрлэх согтууруулах ундааны шошго нь монгол хэлээр байна.

3.Шошгод дээрх шаардлагаас гадна дараах нэмэлт мэдээлэл тавигдаж болно:

3.1.Барааны болон олон улсын үзэсгэлэн, уралдаанаас авсан шагналын тэмдэг, зохистой дадал, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн тухай мэдээлэл;

3.2.Хадгалах хугацаа, хэрэглэж дуусах хугацаа, үйлдвэрлэсэн огноо, хадгалах нөхцөлийг агуулсан QR код бүхий мэдээлэл.

4.Шошгод агуулагдах нэмэлт мэдээллийг олон улсын болон Монгол Улсын техникийн зохицуулалт, стандартаар зохицуулж болно.

5.Гадаад улсад экспортлох бол “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг болон энэхүү тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны шошго, анхааруулгыг загварт тавигдах шаардлага”-ыг мөрдөхгүй байж болно.

6.Согтууруулах ундааны шошгод эрүүл мэндийн мэдэгдэл байршуулахыг хориглоно.

7.Согтууруулах ундааны шошгын мэдээлэл үнэн зөв эсэхийг тухайн үйлдвэрлэгч хариуцна.

---О---

Төсөл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны ... дугаар сарын-ны өдрийн дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

АНХААРУУЛГЫН ЗАГВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.1.Согтууруулах ундааны шошгод хүний эрүүл мэндэд нөлөөлөх хор хөнөөл, гаж нөлөө, хориглох заалтыг тусгасан анхааруулгын загварыг шошгын нүүр хэсэгт байршуулна.

1.2.Анхааруулгын загвар нь шошгын нийт талбайн 10 хувиас хэтрэхгүй хувийг эзэлсэн байна.

1.3. Анхааруулах заалтыг бичвэрээр илэрхийлэх ба дараах бичвэрүүдийг аль нэгнийг нь сонгож хэрэглэнэ.

1.3.1.Хэтрүүлэн хэрэглэх нь хараат байдал үүсгэх эрсдэлтэй.

1.3.2.Бүтээгдэхүүний найрлагад орсон түүхий эдүүдэд хэт мэдрэг хүмүүс анхаарна уу.

1.3.3.Төв мэдрэлийн систем, дотоод эрхтний өвчтэй зэрэг эмчийн заавраар хориглосон хүмүүс анхаарна уу.

1.3.4.Тээврийн хэрэгсэл жолоодож байгаа хүн хэрэглэхийг хориглоно.

1.3.5.Жирэмсэн хүн хэрэглэхийг хориглоно.

1.3.6.Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардахыг хориглоно.

1.3.7.21 нас хүрээгүй хүн хэрэглэхийг хориглоно.

1.4.Анхааруулгын загварын бичвэрийг монгол хэлээр бичиж, шошгын бусад мэдээллийг бичсэн үсгийн хэмжээтэй ижил эсхүл том хэмжээтэйгээр, хэрэглэгчийн анхаарлыг татахуйц хэсэгт байршуулна.

1.5.Анхааруулгын загварын хажууд ямар нэгэн нэмэлт зураг, бичиглэл хийхгүй.

1.6.Уламжлалт технологиор үйлдвэрлэснээс бусад согтууруулах ундаа анхааруулгын загвартай байна.

---О---